

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.. оны ... дугаар сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, хяналт тавих, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль тогтоомж

2.1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Харилцаа, холбооны тухай хууль, Иргэний хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль¹, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрийг дүрсэлсэн, тоон хэлбэр бүхий орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагаанд оролцогч төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд хамаарна.

3.2.Нууцад хамаарах орон зайн өгөгдлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“геопортал” гэж интернэтэд суурилсан орон зайн өгөгдлийг хайх, харах, засварлах, дүн шинжилгээ хийх боломж бүхий цахим үйлчилгээг;

4.1.2.“геоплатформ” гэж геопорталыг хэрэглэгчид хүргэх цахим орчныг;

¹ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 26 дугаарт нийтлэгдсэн.

4.1.3.“иргэн” Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дах хэсэгт заасныг;

4.1.4.“лиценз” гэж орон зайн өгөгдлийг харах, дамжуулах, нийтлэх, хэрэглэх, нэмүү өртөг шингээн ашиг олох зорилгоор өөрчлөхөд эрх бүхий байгууллагаас олгож буй зөвшөөрлийг;

4.1.5.“мета-өгөгдөл” гэж орон зайн өгөгдлийг хайх, бүртгэх, ашиглахад зориулагдсан орон зайн өгөгдлийн тухай мэдээллийн цогцыг,

4.1.6.“орон зайн өгөгдөл” гэж газрын гадаргын дээрх, доорх, ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогцыг;

4.1.7.“суурь орон зайн өгөгдөл” гэж дэлхийн гадаргаас шууд хэмжигдэх буюу хүний нүдэнд харагдах харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх орон зайн өгөгдлийг;

4.1.8.“сэдэвчилсэн орон зайн өгөгдөл” гэж суурь орон зайн өгөгдөлд үндэслэсэн, хил хамгаалах болон батлан хамгаалах, хуулиар төрийн нууцад хамаарах мэдээллийг агуулаагүй орон зайн бусад өгөгдлийг;

4.1.9.“орон зайн өгөгдлийн дэд бүтэц” гэж орон зайн өгөгдлийг бүрдүүлэгч, хэрэглэгч, эдгээрийн хамтын ажиллагааг удирдан зохион байгуулах бодлого, хууль, тогтоомж, стандарт, техник, технологи, хүний нөөцийн цогцыг;

4.1.10.“орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаа” гэж орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх цогц үйл ажиллагааг.

4.1.11.“хуулийн этгээд” гэж Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасныг.

5 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар баримтлах зарчим, түүнийг хэрэгжүүлэх

5.1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.өгөгдөл ил тод, хүртээмжтэй байх;

5.1.2.экологи, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд чиглэсэн байх;

5.1.3.нэгдмэл, оновчтой, үр ашигтай байх;

5.1.4.төр, хувийн хэвшлийн түншлэлийг дээшлүүлэх;

5.1.5.инновацад суурилах.

5.2.Энэ хуулийн 5.1.1-д заасан өгөгдөл ил тод, хүртээмжтэй байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.2.1. орон зайн өгөгдлийг бүрдүүлэгч нь төрийн нууцад хамааруулсан мэдээллийг агуулж буй орон зайн өгөгдлөөс бусдыг дамжуулж ашиглах эрхээр хангах;

5.2.2. орон зайн өгөгдлийг түгээгч нь өгөгдлийн шинэчлэл, өөрчлөлтийн талаар тогтмол мэдээлэх;

5.2.3. энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан мета-өгөгдлийн өөрчлөлтийг шинэчлэх

5.2.4. энэ хуулийн 5.5.1-т заасан сонгон шалгаруулах ажиллагаа, түншлэлийн арга, хэлбэр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, холбогдох төрийн байгууллагаас гаргасан шийдвэр, хувийн хэвшлийн этгээдийг, түншлэлийн үр дүн нийтэд ил тод, нээлттэй байх.

5.3. Энэ хуулийн 5.1.2-д заасан экологи, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд чиглэсэн байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.4. Энэ хуулийн 5.1.3-д заасан нэгдмэл, оновчтой, үр ашигтай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.4.1. энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан хороо нь төрийн байгууллагын орон зайн өгөгдлийн бүрдүүлэх талаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр нь төрөөс баримтлах бодлого, хуульд нийцэж байгаа эсэх талаар үнэлгээ хийж, санал хүргүүлсэн байх;

5.4.2. төрийн байгууллага улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр энэ хуулийн 6.4-т заасан мэдээллийг өөрчлөх, баяжуулах, хэрэглэх чиглэлээр төсөл, хөтөлбөрийг төлөвлөхдөө энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан хорооны саналыг авсан байх;

5.4.3. энэ хуулийн 5.4.2-т заасан саналаас хуульд заасан үндэслэлээр 1 удаа татгалзах эрхтэй ба энэ тохиолдолд зохих тайлбарыг хийсэн байх;

5.4.4. төрийн байгууллага, түүний харьяа нэгж нь бүрдүүлсэн орон зайн өгөгдлөө геоплатформд үнэ төлбөргүй төвлөрүүлэх.

5.5. Энэ хуулийн 5.1.4-д заасан төр, хувийн хэвшлийн түншлэлийг дээшлүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.5.1. төрөөс энэ хуулийн 13.8-д зааснаас бусад хувийн хэвшилтэй хамтран ажиллах тохиолдолд түүнийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгох;

5.5.2. энэ хуулийн 5.5.1-т заасан үндэсний хувийн хэвшлийн хүний нөөцийг бэхжүүлэх, шинэ техник, технологиор хангах замаар дэмжих.

5.6. Энэ хуулийн 5.1.5-д заасан инновацад суурилах зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.6.1. орон зайн өгөгдөл солилцоог олон улсын түвшинд гаргаж, хилийн гаднах орон зайн өгөгдлийг геоплатформд төвлөрүүлэх;

5.6.2. монгол улсын олон улсын өмнө хүлээсэн эрх, үүрэгт 3-5 жил тутамд дүн шинжилгээ хийх;

5.6.3.нээлттэй эх үүсгэвэр бүхий орчныг бүрдүүлж, хөгжүүлэлтийг тогтмол хийх;

5.6.4.хаалттай эх үүсгэвэр бүхий орчинд ажиллах, хаалттай эх код бүхий программ хангамж, бусад хэрэгслийг нээлттэй өгөгдлийн талаар төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн зохистой хэмжээнд нэвтрүүлэх.

5.7.Орон зайн өгөгдөл нь дараах шаардлагыг хангасан байна:

5.7.1.бүрэн байх;

5.7.2.нэгдмэл байх;

5.7.3.уялдаатай байх;

5.7.4.шинэлэг байх;

5.7.5.үнэн зөв, бодитой байх;

5.7.6.зорилгод нийцсэн нарийвчлал хангахуйц байх;

5.7.7.давхардалгүй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ТӨРӨЛ, ДҮРСЛЭЛ, ТЭДГЭЭРИЙН БҮРДЭЛ

6 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн төрөл

6.1.Орон зайн өгөгдөл нь суурь орон зайн өгөгдөл болон сэдэвчилсэн орон зайн өгөгдөл гэсэн төрөлтэй байна.

6.2.Орон зайн өгөгдөл нь вектор, растер форматтай байна.

6.3.Орон зайн вектор өгөгдөл нь цэг, шулуун, полигоноор дүрслэгдэнэ.

6.4.Суурь орон зайн өгөгдөл нь дараах өгөгдлөөс бүрдэнэ.

6.4.1.геодезийн тулгуур сүлжээ;

6.4.2.байр зүйн зураг;

6.4.3.хил зааг;

6.4.4.хаяг;

6.4.5.барилга, суурин газрын мэдээлэл;

6.4.6.өндөржилт, гүний мэдээлэл;

6.4.7.газар зүйн нэр;

6.4.8.газрын бүрхэвч, ашиглалтын мэдээлэл;

6.4.9.газрын нэгж талбарын мэдээлэл;

6.4.10.дэд бүтцийн мэдээлэл;

6.4.11.тээврийн сүлжээний мэдээлэл;

6.4.12.ус зүйн мэдээлэл;

6.4.13.орто зураг;

6.4.14.геологи, хөрсний мэдээлэл;

6.4.15.түүх, соёл, археологийн өвийн мэдээлэл;

6.4.16.хүн ам зүйн мэдээлэл.

6.5.Энэ хуулийн 6.4-т заасан өгөгдөл нь дараах мэдээллийг агуулсан байна:

6.5.1.геодезийн тулгуур сүлжээний мэдээлэл гэдэгт навигацийн, лазерын хиймэл дагуул, маш урт суурь талын интерферометр, астрономи-геодезийн аргаар цэг, тэмдэгтийн орон зай, цаг хугацаа, хүндийн хүчний хамаарлыг тодорхойлсон 3 болон түүнээс дээш хэмжээс бүхий утгыг хамаарна;

6.5.2.байр зүйн зураг гэдэгт газрын гадарга болон түүн дээрх бодит зүйлсийг хавтгайд тодорхой тусгаг, масштабд оруулан томьёолсон тэмдгээр дүрсэлсэн зураг хамаарна;

6.5.3.хил зааг гэдэгт засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил, газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан тусгай хэрэгцээний газрын хил, бүсчлэлийн хил, байгалийн бүслүүр болон байгаль, нийгэм, эдийн засгийн бусад хил, зааг хамаарна;

6.5.4.хаяг гэдэгт газар нутаг, хот, суурин газрын гудамж, зам, талбай, үйлдвэр, аж ахуйн нэгж, хотхон зэрэгт хамаарах үл хөдлөх эд хөрөнгийн байршлыг тодорхойлсон үсэг, тоо хосолсон илэрхийлэл хамаарна;

6.5.5.барилга, суурин газрын мэдээлэл гэдэгт барилга, байгууламж, үл хөдлөх хөрөнгө, байгаль, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаа явагдаж буй хүн ам суурьшсан газрын байршил, өвөлжөө, хаваржааны мэдээлэл хамаарна;

6.5.6.өндөржилт, гүний мэдээлэл гэдэгт газрын болон усан доорх гадаргуугийн мэдээлэл хамаарна;

6.5.7.газар зүйн нэр гэдэгт эх газар, далай, тэнгис, булан, тохой, арал, хойг, уул, нуруу, хээр, тал, говь, цөл, мөрөн, гол, нуур зэрэг физик газар зүйн объектын оноосон нэр, хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, усан сан, суваг, шуудууны оноосон нэр, улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэр хамаарна;

6.5.8.газрын бүрхэвч, ашиглалт гэдэгт газрын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан газрын нэгдмэл сангийн ангиллын мэдээлэл, хүний гараар бүтсэн объект, хөдөө аж ахуйн талбай, ой, байгалийн цогцолборт газар, ус зэрэг дэлхийн гадаргын физик болон биологийн бүрхэвчийн мэдээлэл хамаарна;

6.5.9.газрын нэгж талбар мэдээлэл гэдэгт кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд заасан эдлэн газар, нэгж талбарын байршил,

хэмжээ, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн төрлийн зориулалт, үнэлгээ, төлбөр, татварын мэдээлэл хамаарна;

6.5.10.дэд бүтцийн мэдээлэл гэдэгт харилцаа холбоо, эрчим хүч, дулаан дамжуулах сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам, ус зайлуулах шугам, үерийн далан, суваг, тэдгээрт хамааралтай барилга, байгууламжийн мэдээлэл, нийгмийн дэд бүтцийн мэдээлэл хамаарна;

6.5.11.тээврийн сүлжээний мэдээлэл гэдэгт авто зам, хотын гудамж, гудам, жим, явган хүний зам, дугуйн зам, төмөр зам, өртөө, усан зам, агаарын зам, онгоцны буудал, аэродром, болон тээврийн сүлжээнд хамаарах гүүр, далан, байгууламж, төлөвлөсөн замын батлагдсан чигийн мэдээлэл хамаарна;

6.5.12.ус зүйн мэдээлэл гэдэгт гол, мөрөн, нуур, цөөрөм, горхи, худаг, рашаан, булаг, шанд, усан сан, мөстөл, мөсөн голын мэдээлэл хамаарна;

6.5.13.орто зураг гэдэгт хиймэл дагуул, агаарын хөлгөөс авсан дэлхийн гадаргууг дүрсэлсэн геометрийн засвар хийгдсэн растер мэдээлэл хамаарна;

6.5.14.геологи, хөрсний мэдээлэл гэдэгт газрын хэвлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан газрын хэвлийн мэдээлэл, инженер геологи, гидрогеологи, ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан ашигт малтмалын орд, хөрс, цэвдэг, ургамлын бүрхэвчийн мэдээллүүд хамаарна;

6.5.15.түүх, соёл, археологийн өвийн мэдээлэл гэдэгт соёлын өвийг хамгаалах тухай хуулиар соёлын өвийн бүртгэлд бүртгэгдсэн түүх, соёл, археологийн өвийн мэдээлэл хамаарна;

6.5.16.хүн ам зүйн мэдээлэл гэдэгт статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь дэд хэсэгт хамаарах, энэ хэсэгт тусгайлан заагаагүй бусад мэдээлэл.

6.6.Суурь орон зайн өгөгдлөөс бусад өгөгдөл нь сэдэвчилсэн орон зайн өгөгдлийн төрөлд хамаарна.

6.7.Орон зайн өгөгдлийн төрлийг шилжүүлэх асуудлыг хуулиар зохицуулна.

7 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн мета-өгөгдөл

7.1.Орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулахад түүний мета-өгөгдлийг стандартын дагуу зэрэг бүрдүүлнэ.

7.2.Орон зайн өгөгдлийг геоплатформд байрлуулахдаа дор дурдсан мета-өгөгдлийг нээлттэй байлгана:

7.2.1.солбицлын тогтолцоо, тусгаг;

7.2.2.өгөгдлийн чанар;

7.2.3.өгөгдлийн төрөл;

7.2.4.орон зайн дүрслэл;

7.2.5.бүрдүүлсэн огноо;

7.2.6.мэдээний шинэчлэлт;

7.2.7.хариуцагч этгээд;

7.2.8.орон зайн мэдээллийг ашиглах эрх.

8 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийг түгээх, ашиглах эрх

8.1.Орон зайн өгөгдлийг ашиглах лиценз нь нээлттэй /харах/, үнэгүй /харах, дамжуулах/, үнэтэй /харах, төлбөртэй дамжуулах/, хязгаарлагдмал /бүх эрх/ төрлүүдтэй байна.

8.2.Хэрэглэгч геоплатформд дор дурдсан түвшинд хандана:

8.2.1.энгийн түвшин;

8.2.2.ахисан түвшин.

8.3.Энгийн түвшний хандалтаар хэрэглэгч нээлттэй, үнэгүй лицензээр зохицуулсан орон зайн өгөгдөлд хандана.

8.4.Ахисан түвшний хандалтаар төрийн байгууллага, түүний эрх олгосон бусад мэргэжлийн байгууллагууд хязгаарлагдмал лицензээр хамгаалагдсан орон зайн өгөгдөлд хандана.

8.5.Эрдэм шинжилгээ, судалгаа хийх, сургалтын зориулалтаар ашиглах орон зайн өгөгдлийн лиценз нээлттэй, үнэгүй байна.

8.6.Лицензийг хэрэглэх, олгохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулна.

8.7.Суурь орон зайн өгөгдлийн нарийвчилсан ангилал, агуулга болон сэдэвчилсэн орон зайн мэдээллийн ангилал, тэдгээрийн шинж чанарыг журмаар тогтооно.

8.8.Батлан хамгаалах болон улсын хил хамгаалах зориулалттай, хуулиар төрийн нууцад хамааруулсан орон зайн өгөгдөлтэй холбогдсон харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 8.6-д заасан журмаар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

9 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийг бүрдүүлэх

9.1.Орон зайн өгөгдлийг бүрдүүлэх гэдэгт түүнийг холбогдох стандартын дагуу цуглуулах, шинэчлэх, өөрчлөх, тодотгох, нягтлах үйл ажиллагаа хамаарна.

9.2.Орон зайн өгөгдлийн бүрдүүлэлт нь дараах аргад суурилна:

9.2.1.бүх төрлийн газрын хэмжилт, зураглал;

9.2.2.бүртгэл, тооллого;

9.2.3.шинжлэх ухаан, технологийн ололтод суурилсан бусад арга.

9.3.Орон зайн сэдэвчилсэн өгөгдлийг бүрдүүлэхдээ ашиглаж буй суурь орон зайн өгөгдлийн байрлал, өндрийн нарийвчлалыг багасгах, масштабыг томруулах байдлаар өөрчлөлт оруулахыг хориглоно.

9.4.Суурь орон зайн өгөгдлийг энэ хуулийн 15.7.2-т заасан нэгдсэн бодлогын дагуу монгол улсын нутаг дэвсгэрийг хамруулан бүрдүүлнэ.

9.5.Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр бүрдүүлсэн орон зайн өгөгдлийг бүрдүүлэгчийн хандах эрхтэйгээр геоплатформд төвлөрүүлнэ.

9.6.Орон зайн өгөгдлийн үнэн зөв байдлыг бүрдүүлсэн этгээд хариуцна.

10 дүгээр зүйл.Орон зайн өгөгдлийг боловсруулах

10.1.Орон зайн өгөгдлийг боловсруулах гэдэгт түүнд математик боловсруулалт хийх, дүрслэх үйл ажиллагаа хамаарна.

10.2.Орон зайн өгөгдлийн боловсруулалт нь дараах шаардлагыг хангасан байна:

10.2.1.монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд байх;

10.2.2.энэ хуулийн 7.1-т заасны дагуу мета-өгөгдлийг бүрдүүлсэн байх;

10.2.3.өргөтгөл, өгөгдлийн сан, мета-өгөгдлийн хувьд суурь орон зайн өгөгдөлтэй стандартын дагуу холбох боломжтой байх.

10.3.Орон зайн өгөгдлийг геопорталд дараах байдлаар дүрсэлнэ:

10.3.1.солбицлын жагсаалт;

10.3.2.тоон газрын зураг;

10.3.3.интерактив газрын зураг;

10.3.4.мультимедиа газрын зураг;

10.3.5.гурван хэмжээст загвар.

10.4.Энэ хуулийн 10.3.1-т зааснаас бусад орон зайн өгөгдлийн дүрслэл нь түүний эх өгөгдлийн нарийвчлал, хэрэглэх зориулалтад нийцсэн масштаб, нарийвчлал, агуулгатай байна.

10.5.Орон зайн өгөгдлийн боловсруулалтыг нээлттэй эх үүсгэвэр бүхий үйлдлийн системийн орчинд ажиллах боломжтой программ хангамж ашиглан гүйцэтгэнэ.

10.6.Орон зайн өгөгдлийг боловсруулах үйл ажиллагааг монгол улсын нутаг дэвсгэр дээрээс удирдаж, гүйцэтгэнэ.

10.7.Орон зайн өгөгдлийг боловсруулалтын аль нэг үе шатыг дотооддоо гүйцэтгэх боломжгүй гэж тагнуулын байгууллага үзэн зохих зөвшөөрлийг өгсөн бол

тухайн үе шатны боловсруулалтыг гадаад улсын нутаг дэвсгэрээс удирдаж, гүйцэтгэж болно.

11 дүгээр зүйл.Орон зайн өгөгдлийг хадгалах, хамгаалах

11.1.Орон зайн өгөгдлийг хамгаалах гэдэгт тухайн өгөгдөл гэмтэхгүй, алдагдахгүй, гаднын халдлагад өртөхгүй байх нөхцөлд байршуулахад чиглэсэн үйл ажиллагаа хамаарна.

11.2.Үүлэн технологи, машины суралцах чадварт суурилан боловсруулсан өгөгдлийг шаардлагатай тохиолдолд физик төхөөрөмжид файл хэлбэрээр хадгалж болно.

11.3.Орон зайн өгөгдлийг хадгалах сервер нь улсын хамгаалалтад байх ба тэдгээрийн байрлал нь нууц байна.

11.4.Орон зайн өгөгдлийг хамгаалах асуудлыг хуулиар зохицуулна.

12 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийг түгээх

12.1.Орон зайн өгөгдлийг түгээх гэдэгт геоплатформоор дамжуулан энэ хуулийн 8.1-д заасан лицензээр зохицуулагдсан орчинд өгөгдлийг нийтлэх, түгээх, солилцох үйл ажиллагаа хамаарна.

12.2.Суурь орон зайн өгөгдлийг геоплатформоор дамжуулан нэгдсэн байдлаар түгээх ба орон нутаг, улсын хэмжээнд гэсэн шатлалтай байж болно.

12.3.Орон зайн өгөгдлийг түгээхтэй холбогдсон шийдвэр нь энэ хуулийн 5.1-т заасан зарчимд нийцсэн байна.

13 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн хэрэглэх

13.1.Орон зайн өгөгдлийг хэрэглэх гэдэгт тухайн өгөгдлийн үр өгөөжийг шууд ба шууд бус байдлаар хүртэх үйл ажиллагаа хамаарна.

13.2.Иргэн, хуулийн этгээд нь ашиг олох зорилгоор орон зайн өгөгдлийг хэрэглэхдээ энэ хуулийн 8.6-т заасан журмыг баримтална.

13.3.Орон зайн өгөгдлийг хэрэглэхдээ түүний эх сурвалжийг дурдсан байна.

13.4.Аливаа төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн орон зайд суурилсан бодлого, төлөвлөлт, шийдвэр, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь геоплатформоор дамжуулан түгээж буй орон зайн өгөгдөлд үндэслэсэн байна.

13.5.Энэ хуулийн 13.4-т заасныг зөрчиж, шийдвэр гаргасан бол албан тушаалтныг төрийн албанаас чөлөөлөх үндэслэл болно.

13.6.Суурь орон зайн өгөгдлийг хууль бусаар олж авах, ашиглах, өөрчлөн ашиглах замаар ашгийн төлөө үйл ажиллагаа явуулсан иргэн, хуулийн этгээдийн холбогдох үйл ажиллагааг түүнийг бий болгоход гаргасан зардлыг нөхөн төлөхгүйгээр зогсооно.

13.7.Гамшиг, гэнэтийн осол болон онц байдлын үед төрөөс иргэн, хуулийн этгээдийн эзэмшилд байгаа орон зайн сэдэвчилсэн өгөгдлийг хуулийн дагуу гаргуулан авна.

13.8.Монгол улсын иргэн, хуулийн этгээдийн дараах шалгуурын 3 ба түүнээс дээш үзүүлэлтийг хангаж буй орон зайн өгөгдөлд суурилсан ухаалаг үйлчилгээнд төрөөс дэмжлэг үзүүлж болно:

13.8.1.өөрийн хөрөнгөөр бий болгосон;

13.8.2.тухайн үйлчилгээгээр импортын зардлыг 30 хувиас дээш хэмнэж байгаа;

13.8.3.олон улсад өрсөлдөхүйц хэмжээнд хүрсэн;

13.8.4.боломжит дотоодын хэрэглэгчдийн 60-аас дээш хувь нь тогтмол ашиглаж байгаа;

13.8.5.үйлчилгээгээ нэвтрүүлснээр бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчид хүргэх өртгийг 20 ба түүнээс дээш хувиар буруулсан.

13.9.Энэ хуулийн 13.8-д заасан иргэн, хуулийн этгээдэд төрийн дэмжлэгийг тэдгээрийн гаргасан саналыг харгалзан дараах хэлбэрээр үзүүлнэ:

13.9.1.төрийн зарим чиг үүргийг хариуцуулах;

13.9.2.засгийн газрын тусгай сангаас 1 удаа буцалтгүй тусламж үзүүлэх;

13.9.3.хөнгөлөлттэй эсхүл хүүгүй зээлийг 2 хүртэл удаа олгох;

13.9.4.5 жилийн хугацаанд үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах урсгал зардлын 60 хувийг санхүүжүүлэх;

13.9.5.нөхөх олговортойгоор төрийн мэдэлд шилжүүлэх

13.9.6.5 жилийн хугацаанд төрийн мэдлийн дэд бүтэц, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг үнэ төлбөргүй эзэмшүүлэх, ашиглуулах.

13.10.Энэ хуулийн 13.9-д заасан шийдвэрийг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн хороо эсхүл түүний эрх олгосноор бусад төрийн байгууллага гаргана.

14 дүгээр зүйл.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн техникийн баримт бичгийн тогтолцоо

14.1.энэ хуулийн 9-12 дугаар зүйлд заасан техникийн зохицуулалтад стандарчлал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 5.1, 8.1.1, барилгын тухай хуулийн 5.1.1-т заасан баримт бичгийг ашиглана.

14.2.техникийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа орон зайн өгөгдлийн түгээх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авсан байна.

14.3.техникийн баримт бичиг нь энэ хуулийн 5.1-т заасан зарчимд нийцсэн байна.

14.4.техникийн баримт бичгийг боловсруулах, батлах, сурталчлах зэрэг үйл ажиллагааны зардлыг улсын төсөв болон энэ хуулийн 17.2-т заасан сангаас санхүүжүүлнэ.

14.5.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн удирдлага, зохион байгуулалтын шинжтэй журам, улсын байцаагчийн дүрэм нь техникийн баримт бичгийн тогтолцоонд хамаарахгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ

15 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үндэсний хороо

15.1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үндэсний хороо /цаашид “хороо” гэх/ нь Монгол Улсын үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хууль, тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ, төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

15.2.Хороог байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Орон зайн өгөгдлийн түгээлтийг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын өргөн мэдүүлснээр Засгийн газар шийдвэрлэнэ.

15.3.Хороо нь дарга, гишүүд, нарийн бичгийн дарга гэсэн бүтэцтэй байх ба Засгийн газрын бүтцээс хамааруулан 9-13 гишүүнтэй байна.

15.4.Хорооны дарга, гишүүнийг Монгол улсын Ерөнхий Сайд томилж, чөлөөлнө.

15.5.Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна.

15.6.Хорооны даргаар газарзүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлал, газрын хэмжилт, зураглалын чиглэлээр дээд боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг томилно.

15.7.Хороо нь орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар дараах үйл ажиллагааг Засгийн газрын өмнө хариуцна:

15.7.1.орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, түүний хэвийн үйл ажиллагааг хангах;

15.7.2.орон зайн өгөгдлийн дэд бүтцийг хөгжүүлэхтэй холбоотой хууль, тогтоомж, бодлого, стандарт, журмыг боловсруулах ажлыг зохион байгуулах;

15.7.3.энэ хуульд заасан журмын дагуу лицензийн төлбөрийн хэмжээг тогтоох;

15.7.4.хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, эдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хорооны шийдвэрийн биелэлтийг хангуулах;

15.7.5.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн оролцогч талуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

15.7.6.энэ хуулийн 15.1-т заасан чиг үүргийн хүрээнд монгол улсын олон улсын гэрээний төсөл боловсруулах, хэрэгжилтийг хангуулах;

15.7.7.хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасан журмыг батлах;

15.7.8.орон зайн өгөгдөл мэдээлэлд суурилсан ухаалаг үйлчилгээ нэвтрүүлсэн иргэн, хуулийн этгээдийг шагнах, урамшуулах, дэмжлэг үзүүлэх саналаа эрх бүхий байгууллагад уламжлах;

15.7.9.тухайн жилд орон зайн өгөгдлийн дэд бүтцийн чиглэлээр хийсэн ажлыг тайлагнах.

15.8.Хорооны ажиллах журмыг орон зайн өгөгдлийг түгээх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өргөн мэдүүлснээр Засгийн газар батална.

15.9.Хорооны үйл ажиллагаа нь хурлын хэлбэртэй, шийдвэр нь тогтоол, тэмдэглэл, зөвлөмж хэлбэртэй байна.

15.10.Хорооны хурлыг нийт гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчинтэйд тооцно.

15.11.Хороо нь аливаа асуудлыг илээр, ердийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

15.12.Хорооны шийдвэрт хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

15.13.Хороо нь өдөр тутмын ажлыг уялдуулан зохион байгуулах ажлын албатай байна.

15.14.Ажлын албаны чиг үүргийг орон зайн өгөгдлийн түгээх асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх ба Хорооны нарийн бичгийн дарга нь ажлын албаны дарга байна.

15.15.Хороо нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

15.16.Хорооны харьяанд орон зайн өгөгдлийн талаар дагнасан байнгын бус ажиллагаатай дараах дэд хороодыг энэ хуулийн 6.4.1-т заасан байгууллагын төлөөллөөс оролцуулан байгуулж болно.

15.16.1.стандарт орчныг сайжруулах

15.16.2.өгөгдөл хуваалцах, түгээх

15.16.3.цахим засаглалд холбох

15.16.4.хүний нөөц бэлтгэх

15.16.5.бизнес загвар хөгжүүлэх

15.17.Дэд хороог хорооноос сонгосон гишүүн ахлах ба зохих байгууллага эсхүл бусад дэд хороотой хамтран судалгаа хийх, шийдвэрийн төсөл боловсруулах,

хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг судлан санал гаргах ба хорооны хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

15.18.Дэд хороог хорооны даргын шийдвэрээр байгуулна.

16 дугаар зүйл. Үйлчилгээ эрхлэх байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг

16.1.Орон зайн өгөгдөлд суурилсан контентын үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж нь дараах үүрэгтэй:

16.1.1.орон зайн өгөгдлийн контентын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх;

16.1.2.орон зайн өгөгдөлд суурилсан контентын үйлчилгээ нь энэ хуулийн 13.2, 13.3, 13.4, 13.6-д заасныг зөрчихгүй байх.

16.2.Орон зайн өгөгдөлд суурилсан контентын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүсэгч аж ахуйн нэгж нь аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараах нөхцөлийг хангаж байгааг нотлох баримт бичгийг бүрдүүлсэн байна:

16.2.1.газар зүйн мэдээллийн системийн инженертэй байх;

16.2.2.холбогдох стандарт, норматив баримт бичигтэй байх.

Тайлбар: Энэ хуулийн 16.2-д заасан орон зайн өгөгдөлд суурилсан контентын үйлчилгээ гэдэгт эзэмшигчээс орон зайн өгөгдлийг өөрчлөх, нэмэх, устгах, вектор хэлбэрээр хадгалах эрхийг хэрэглэгчид олгосон үйлчилгээ хамаарна.

17 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааны санхүүжилт

17.1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг сайжруулах, суурь орон зайн өгөгдлийг бүрдүүлэх үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

17.2.Орон зайн өгөгдлийг ашиглах эрхийн хүрээнд төвлөрсөн орлогын 20 хувь, энэ чиглэлийн гадаад, дотоодын хандив, тусламжийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан санд төвлөрүүлж, энэ хуульд нийцсэн зорилтот арга хэмжээнд зарцуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН УЛСЫН ХЯНАЛТ

18 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн улсын байцаагч

18.1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий улсын ахлах байцаагч, улсын байцаагч орон зайн өгөгдлийг түгээх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байна.

18.2.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн улсын байцаагч нь Орон зайн өгөгдлийн бүрдүүлэх, хамгаалах, түгээх, хэрэглэх ажиллагаанд хяналт тавих мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.2.1.энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан байгууллага, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

18.2.2.энэ хуулийн 13.4-т заасныг зөрчсөн албан тушаалтныг төрийн албанаас чөлөөлүүлэх, гаргасан шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

18.2.3.энэ хуулийн 7.1,8.6,9.3,13.2,13.6-д заасан журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн зөрчлийн шинж байдал нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрхэлж буй үйлчилгээг хүчингүйд тооцуулахаар хороонд санал оруулах;

18.2.4.энэ хуулийн 17.2-т заасныг зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай дүгнэлт гаргаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

18.3.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн улсын байцаагчийн ажиллах дүрмийг орон зайн өгөгдөл мэдээллийг түгээх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД

19 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

19.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

19.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

20 дугаар зүйл.Хүчин төгөлдөр болох

20.1.Энэ хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар нь Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай хороог байгуулах, хуульд заасан журмыг боловсруулж, батлах, хууль тогтоомжийг сурталчлах, зохион байгуулалтын болон техник хэрэгсэл, санхүү, эдийн засгийн холбогдох арга хэмжээг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулна.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 12.12 дугаар зүйл нэмсүгэй:

“12.12 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль зөрчих

1. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн 5.4.1, 5.4.3, 5.4.4, 5.5.1, 8.5, 8.6, 9.5, 10.2, 10.7, 12.3, 13.4, 13.2, 13.8, 13.9-д заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албан тушаалтныг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, байгууллагыг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн 7.1, 9.3, 9.6, 10.2, 13.2, 13.7, 13.6, 13.8, 16.1-т заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг барагдуулж, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

